



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 1146

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаааа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар ыөжхмөзүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт зохицуулалт хийх тухай” 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хөрс бууц бэлтгэх, Ойн зурваст усалгааны системийг шийдвэрлэх, худалдан авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүн:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн засаг дарга)

М.Мөнхзаяа

(Бэлчээр газар тариалан худаг уст цэг хариуцсан мэргэжилтэн)

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих арга хэмжэ”-ний хүрээнд хөрс бууц бэлтгэх, ойн зурваст усалгааны системийг шийдвэрлэх ажилд 6.000.000 (Зургаан сая) төгрөгийг зарцуулсугай.

3.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний зарцуулагдах 6.000.000 (зургаан сая төгрөг)-ийг орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг (Тэрбум мод үндэсний хөдөлгөөний ажлын хэсэг)-т, захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг засаг даргын орлогч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2023 оны
 05... -р сарын 08 ний өдрийн 176...
 дугаар захирамжийн хавсралт

Хөрс бууц бэлтгэх, ойн зурваст усалгааны системийг шийдвэрлэх худалдан авах ажлын төсөв

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын нэр		Тоо ширхэг	Нэгжийн үнэ/төг/	Нийт үнэ /төг/
	Шатахуун	Дизель			
Хөрс бууц бэлтгэх		Дизель	250 литр	4000	1.000.000
Ойн зурваст усалгааны системийг шийдвэрлэх	Усалгааны систем дагалдах хэрэгсэл			5.000.000	5.000.000
Нийт					6.000.000